



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Монгол Улсын Их Сургууль
Бизнесийн сургууль

Сургалтын хөтөлбөрийн нэр: “Маркетинг” хөтөлбөр

Индекс: 041401

Шинжээчийн баг:

Ахлагч: Б. Нарангэрэл – ШУТИС – ийн Бизнесийн ахисан түвшний сургуулийн профессор

Гишүүд: С. Эрдэнэтуул – Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Хөтөлбөрийн бодлого, зохицуулалт хариуцсан захирал

С. Түвшинзаяа - СЭЗИС – ийн Ахисан түвшний сургалтын албаны дарга

Он сар өдөр: 2019 оны 3-р сарын 10.

Агуулга

Хуудас

Товчилсон үгийн тайлбар	4
I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт	5
II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга.....	6
III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт	7
Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт.....	7
Шалгуур 2: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл.....	11
Шалгуур 3: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт.....	14
Шалгуур 4: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа.....	21
Шалгуур 5: Багшийн үйл ажиллагаа.....	25
Шалгуур 6: Сургалтын үйл ажиллагаа.....	29
Шалгуур 7: Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө.....	32
Шалгуур 8: Чанарын үнэлгээ, баталгаажилт.....	35
IV. Оролцогчдын нэрс	39
I. Ярилцлагад оролцсон багш нарын нэрс.....	39
II. Оюутны нэр.....	40
III. Ажил олгогч.....	41
IV. Төгсөгчид.....	41
V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал.....	42
VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр	43
VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр	44

Товчилсон үгийн тайлбар

- МУИС-Монгол Улсын Их сургууль
- БС- Бизнесийн сургууль
- ACBSP-Олон улсын Эдийн засаг бизнесийн сургууль, хөтөлбөрийг магадлан итгэмжлэх байгууллага
- ШУТИС – Шинжлэх ухаан технологийн их сургууль
- ОУ- Олон улсын
- БШУ- Боловсрол, шинжлэх ухаан
- ХҮДС- Худалдаа үйлдвэрийн дээд сургууль
- БНХАУ- Бүгд Найрамдах Хятад Ард Улс
- БНСУ- Бүгд Найрамдах Солонгос Улс
- МХТ-
- ГЕГ- Гаалийн ерөнхий газар
- ТББ- Төрийн бус байгууллага
- ЕШ-Ерөнхий шалгалт
- МҮХАҮТ-Монголын Худалдаа Аж Үйлдвэрий Тэнхим
- ММХ- Монголын Маркетингийн Холбоо
- ННХ-Нээлттэй Нийгэмлэг Хүрээлэн

I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Монгол улсын Их сургууль, Бизнесийн сургууль National University of Mongolia, Business School	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Маркетинг Marketing	
Индекс	041401	
Шинжээчид	Ахлагчийн нэр, ажил, албан тушаал: 1. Б. Нарангэрэл – ШУТИС – ийн Бизнесийн ахисан түвшний сургуулийн профессор Гишүүдийн нэр, ажил, албан тушаал: 1. С. Эрдэнэтуул – Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Хөтөлбөрийн бодлого, зохицуулалт хариуцсан захирал 2. С. Түвшинзаяа - СЭЗИС – ийн Ахисан түвшний сургалтын албаны дарга	
БМИҮЗ-ийн зохицуулагч	Зохицуулагчийн нэр, албан тушаал: Б.Мядагмаа – БМИҮЗ -ийн Ахлах мэргэжилтэн	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Зохицуулагчийн гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2019-II/15- II/21	Маркетингийн хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг судлах
	2019-II/22	Шинжээчийн урьдчилсан үнэлгээг БМИҮЗ-д ирүүлэх
	2019-II/27- II/28	Сургуульд очиж ажиллах, ярилцлага уулзалт хийх
	2019-II/29- III/9	Шинжээчийн эцсийн тайлан бичих
	2019-III/10	Шинжээчийн эцсийн тайланг БМИҮЗ-ийн Ажлын албанд хүлээлгэн өгөх
Шалгуур шаардлага /журам/	Батлагдсан шалгуур шаардлагын дагуу	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Маркетингийн бакалаврын сургалтын хөтөлбөрийн товч танилцуулга

Товч мэдээлэл

- Хөтөлбөрийн нэр, индекс: **Маркетинг, 041401**
- Олгох боловсролын зэрэг: **Бакалавр**
 - Төрөлжсөн чиглэл: *041 Бизнес ба удирдахуй ухаан*
 - Нарийвчилсан чиглэл: *0414 Маркетинг, зар сурталчилгаа*

2009 онд үндэсний хэмжээнд анх удаа магадлан итгэмжлэлд хамрагдсан. **2013** онд олон улсын ACBSP байгууллагаар магадлан итгэжлэл хийлгэсэн. Одоо Бизнесийн сургуулийн Маркетинг, Худалдааны тэнхимийн дэргэд хэрэгжиж байна.

Хөтөлбөрийн эрхэм зорилго:

- *Маркетингийн салбартаа даяарших мэдлэг чадвартай судлаач, манлайлагчийг бэлтгэнэ.*

Тэнхим, хөтөлбөрийн элсэлт, төгсөлт:

- **1954** онд Худалдааны эдийн засагч болон Бараа судлаач мэргэжлээр анхны мэргэжилтнүүдийг бэлтгэж эхэлсэн.
- **1992** оноос эхлэн зах зээл судлаач, маркетингийн мэргэжлийн бакалаврын элсэлтийг зохион байгуулж байна.
- **1959** оноос хойш нийт **3000** орчим мэргэжилтэн бэлтгэжээ.
- **1996** оноос Маркетингийн мэргэжлээр **25** удаагийн төгсөлт хийж, нийт **460** мэргэжилтэн бэлтгэсэн байна.

Тэнхимийн багшлах бүрэлдэхүүний бүтэц

Нийт 13 багштай. 61.5 % нь докторын зэрэгтэй.

Үүнээс: Профессор- 2 (15.3%)
Зөвлөх профессор – 1 (7,7%)
Дэд профессор- 3 (23%)
Ахлах багш – 3 (23%)
Багш – 4 (30,8%)

Маркетинг хөтөлбөрийн бүтцийн өөрчлөлт:

2013 он хүртэл МУИС-ийн ЭЗС-ийн Маркетинг, олон улсын худалдааны тэнхим

2014 МУИС-ийн БС-ийн Маркетингийн хөтөлбөр

2017 оноос МУИС-ийн БС-ийн Маркетинг худалдааны тэнхим

- 2014 онд хийгдсэн дээд боловсролын шинэчлэлттэй холбоотой их, дээд сургуулиудыг нэгтгэхэд МУИС, ХҮДС-уудад хэрэгжиж байсан хөтөлбөрүүдийг нэгтгэн хэрэгжүүлэх болсон.
- 2017-2018 оны хичээлийн жилээс ХҮИС МУИС-иас эргэн салж, тусдаа байгуулагдах болсноор БС-д хэрэгжүүлж байсан хөтөлбөрүүдийн багшлах бүрэлдэхүүн болон анги, танхим, материаллаг орчинд өөрчлөлт орсон.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийсэн байдал
- Төгсөгчийн /мэргэжилтний/ загвар
- Хөтөлбөрийг индексийн хувьд ижил салбар, чиглэлийн гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан байдал /ялгаатай, давуу, сул тал, сайжруулалт/
- МУИС – ийн БС – ийн “Маркетинг” хөтөлбөр нь сургуулийн түүхийг дагасан олон жилийн түүхтэй энэ чиглэлээр мэргэжилтэн бэлтгэсэн анхдагч хөтөлбөрүүдийн нэг хэмээн тодорхойлж болохоор байна. Нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг мэдэрч, сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрүүдэд шинэчлэлт, сайжруулалт хийж иржээ. Маркетингийн хөтөлбөр нь анх 2009 онд үндэсний хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн бөгөөд 2013 онд ОУ – ын магадлан итгэмжлэлийн байгууллага болох ACBSP–ээр магадлан итгэмжлэгдсэн байна. Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, ажил олгогчдын судалгаа, суралцагсдаас авах сэтгэл ханамжийн судалгаа зэрэг оролцогч талуудын судалгааг МУИС–ийн БС- ийн хэмжээнд томоохон төслийн ажил болгон хэд хэдэн удаа зохион байгуулсан бөгөөд энэхүү судалгааны үр дүнг хөтөлбөрийн шинэчлэлд үндэслэл болгосон. Тухайн хөтөлбөрөөр төгсөгчийн загварыг нийтлэг болон тусгай гэсэн 2 бүлэгтэйгээр тодорхойлон гаргасан..

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оролцогч талуудын эрэлт хэрэгцээг хөтөлбөрийн шинэчлэлд тусгах оролдлогыг хийж, хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага, ажил олгогчдын судалгаа, суралцагсдын сэтгэл ханамжийн судалгааг салбар сургуулийн хэмжээнд зохион байгуулж, үр дүнг хөтөлбөрийн шинэчлэлд тусгасан.

- *Хөтөлбөрийн бодлого тодорхойлоход оролцогч талуудын оролцоог хангах зорилгоор төгсөгчдийн төлөөлөл, ажил олгогчдын төлөөллийг оролцуулдаг. Энэхүү оролцоог нотлох нотолгоо болгон БС–ийн захирлын тушаалаар хөтөлбөрийн хорооны гишүүдийг баталгаажуулсан тушаалуудтай танилцсан.*
- *Хөтөлбөрийн зорилго, зорилт, хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдийг дэлхийн шилдэг их сургуулиудын хөтөлбөр, ялангуяа маркетингийн чиглэлээр топ түвшний сургуулийн хөтөлбөртэй харьцуулсан. Харьцуулан судалсан хөтөлбөрүүдийн заавал судлах хичээлүүдийн 60–аас дээш хувьтай энэхүү хөтөлбөрийн заавал судлах хичээлүүд давхцаж байгаа нь ОУ – ын чиг хандлага, мэргэжлийн стандарт, мэргэшлийн хүрээний ОУ – ын жишгийг хангасан хэмээн үзэж байна. Ялангуяа маркетингийн хөтөлбөрөөр дэлхийд алдартай хэмээн үнэлэгддэг ОУ – ын чансаа тогтоодог байгууллагуудын судалгаагаар эхний 10 – т эрэмбэлэгдсэн сургуулиудын хөтөлбөртэй харьцуулалт хийсэн.*
- *Төгсөгчийн загварыг нийтлэг чадамж болон шинжлэх ухааны, семинарын тусгай чадамж гэсэн 3 бүлэг болгон 55 чадамжаар нарийвчлан тодорхойлсон.*

Анхаарах асуудал:

- *Хөдөлмөрийн зах зээлийн болон ажил олгогчдын судалгаа нь салбар сургуулийн хэмжээнд хийгдсэн тул, тухайн хөтөлбөрийн талаар нарийвчилсан мэдээлэл авах боломжийг тэр бүр олгохгүй тул, тэнхим өөрийн судалгааны санг бүрдүүлэх, хөтөлбөрийн дотоод үнэлгээнд энэхүү судалгааны үр дүнг тусган хэвшүүлэх.*
- *Төгсөгчийн загварыг боловсруулахад оролцогч талуудын оролцоо ямар байгааг тодорхой харах боломжгүй. Түүнчлэн хөтөлбөр маркетинг, зар сурталчилгаа гэсэн 2 чиглэлээр мэргэших боломжийг олгож байгаа боловч, мэргэжлийн чадамжид зар сурталчилгаатай холбоотой хэсгүүд тусаагүй байна.*

Зөвлөмж:

- *Хөтөлбөрийг үндэсний хэмжээний ижил төстэй хөтөлбөрүүдтэй харьцуулан судалж, өөрийн хөтөлбөрийн онцлог, ялгарах давуу талуудыг тодорхойлох нь хөтөлбөрийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд тустай;*
- *Хөтөлбөрийн шинэчлэлд хөдөлмөрийн зах зээлд шинээр бий болж буй ажлын байрууд, түүнд тавигдаж буй шаардлагуудыг тусгахаас гадна тухайн хөтөлбөрөөр төгсөгчийн хөрвөж болох ажлын байруудын талаар тусгах;*

1.2 Хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилго

Хөтөлбөрийн үзэл баримтлал тодорхой; төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлага нь мэргэжлийн салбарын хөгжил, зах зээлийн эрэлтэд нийцсэн байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримталж байгаа үзэл баримтлал, сургалтын арга зүй, тогтсон үнэлгээний систем
- Хөтөлбөрийн хүрэх үр дүн, онцлог, сургуулийн эрхэм зорилго, зорилттой нийцсэн байдал
- Төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч, сонирхогч талуудын саналыг тусгаж, хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт төлөөллийг оролцуулсан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- *Мэргэжлийн зарим гол хичээлүүдийг “хамтлагаар” зохион байгуулах зохицуулалтыг хийсэн нь оновчтой зохицуулалт болжээ. “Маркетингийн үндэс” хичээлийг заах 5 багш хамтлагийн зохион байгуулалтад орж, хичээлийн хөтөлбөр, сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтад хэрэглэгдэх идэвхитэй аргууд, үнэлгээний аргуудыг харилцан санал солилцсоны үндсэн дээр нэгдсэн байдлаар боловсруулж, үнэлгээний үр дүнд хамтдаа шинжилгээ хийн ажиллаж байна.*
- *Сургуулийн зорилго, салбар сургуулийн зорилго харилцан уялдаатай судалгаанд суурилсан их сургуулийн хөгжлийг чиг баримжаа болгосон байна.*

Анхаарах асуудал:

- *Салбар сургуулийн зорилго, хөтөлбөрийн зорилгыг уялдаатай тодорхойлсон хэмээн өөрийн үнэлгээнд тусгасан боловч, хөтөлбөрийн зорилго, сургалтын арга хэлбэрүүд, үнэлгээний арга зүй сургуулийн зорилгыг биелүүлэхэд хэрхэн хувь нэмэр үзүүлэхийг тодорхойлсон зураглал гараагүй байна.*

Зөвлөмж:

- *Бизнесийн сургуулийн зорилго, хөтөлбөрийн зорилго, суралцахуйн зорилтот үр дүнгүүдийн холбоог зураглалаар гаргаж, хөтөлбөрт оруулах;*
- *Хөтөлбөрийн тэргүүлэх зорилтуудад шинэлэг, шилдэг судалгааг хөгжүүлэх, судалгаанд суурилсан сургалт явуулах хэмээн тодорхойлсон тул энэ зорилтыг биелүүлэхэд хувь нэмэр үзүүлэх сургалтын арга хэлбэр, үнэлгээний арга зүйг хөтөлбөрт тусгах;*

1.3 Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга; сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй; сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тогтмол тусган сайжруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангаж, баталгаажуулсан байдал
- Сургалтын төлөвлөлт нь онол, практикийг зохистой хослуулсан, суралцагчийн мэргэжлийн болон хувь хүний ур чадваруудыг хөгжүүлэхэд чиглэсэн байдал
- Хичээлийн хөтөлбөр нь хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, агуулга, ур чадварын хувьд харилцан залгамж холбоотой, сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт арга, хэлбэрийг тусгасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- *Дээд боловсролын тухай хууль, БШУ – ны сайдын А/174 тоот тушаалын “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”, БШУ – ны сайдын ерөнхий суурийн хичээлийн жагсаалт, сонгох сургалтын боломж зэргийг бүрэн хангасан байна.*
- *Сургалтын төлөвлөгөө нь онол, практикийг хослуулсан, 32 цагийн лекц, 32 цагийн семинар хэлбэрээр зохион байгуулагддаг бөгөөд сургалтад кейс дээр ажиллах, багаар ажиллах, дүрд хувирах зэрэг сургалтын идэвхитэй аргуудыг ашиглаж байна.*
- *Суралцагсдад дотоод ур чадвар (soft skill - дотоод ур чадварт тухайн ажлыг хийхэд шаардагдах хувь хүний шинж чанар, хувийн онцлог шинж, нийгмийн төрөлх шинж буюу харилцааны ур чадварууд багтдаг) олгох зорилгоор ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлүүдэд багаар ажиллах, өөрийгөө илэрхийлэх, шүүмжлэлт болон бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх даалгаваруудыг хийлгэхээс гадна сургалтын программаар дамжуулан цагийн менежментийн зөв хандлагыг суулгахыг зорьж байна.*

Анхаарах асуудал:

- *Маркетингийн хөтөлбөр нь суралцагсдад маркетинг болон зар сурталчилгааны чиглэлээр мэргэших боломжийг олгохоор боловсруулагдаж, мэргэшүүлэх хичээлийн багцад 5 төрлийн 15 багц цагийн хичээлийг санал болгож байгаа боловч, хөтөлбөрөөр төгсөгчийн загварт энэ чиглэл тусаагүй. Түүнчлэн БШУ – ны сайдын баталсан мэргэжлийн чиглэл, индексийн хувьд “Маркетинг, D041401” гэсэн индекс л олгох боломжтой байгааг анхааран, хэрэв оюутан зар сурталчилгаагаар төгссөн нөхцөлд дипломын нэршил, мэргэшлийг тодорхой болгох.*
- *Хөтөлбөрийн зорилго, зорилт, суралцахуйн зорилтот үр дүнгүүд, сургалтын арга хэлбэр, үнэлгээний арга хэрэгслийн уялдааг харах маппинг хийгдээгүй байна.*

- *Хөтөлбөрөөр тасралтгүй суралцаж байгаа (retention rate - элсэлтээс төгсөлт хүртэл тасралтгүй тухайн хөтөлбөрөөр үргэлжлүүлэн суралцаж буй суралцагсдын хувь) болон шилжилт хөдөлгөөн хийсэн оюутны судалгаа тэнхимийн хувьд хийгдэхгүй байгаа нь хөтөлбөрийн удирдлагын хувьд хөтөлбөрийн бодлогыг тодорхойлоход зайлиггүй хийх ёстой зүйл хэмээн харж байна.*

Зөвлөмж:

- *Хөтөлбөрийн зорилго, зорилт, суралцахуйн зорилтот үр дүн, сургалтын арга хэлбэр, үнэлгээний аргыг уялдаа холбоотойгоор хөтөлбөрт нарийвчлан тусгах. Түүнчлэн хичээлийн хөтөлбөрт хичээлийн зорилтот үр дүнгүүд хөтөлбөрийн зорилготой хэрхэн уялдахыг харуулах, хөтөлбөрийн маппинг хийх шаардлагатай.*
- *Үндсэн болон өмнөх, давхар холбоотой хичээлүүдийн өөр хоорондын уялдаа холбоог зураглалаар(flowchart) харуулж, хөтөлбөрийн баримт бичигт тусаагүй байна. Түүчлэн хөтөлбөрт өөрчлөлт оруулах, хөтөлбөрийн баталгаажуулалтыг хэн хийх, ямар давтамжтайгаар хийх эсэх талаар хөтөлбөрийн баримт бичигт тодорхой тусгах;*

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн эсэхэд дүгнэлт хийх

2.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Эрүүл, аюулгүй, тохилог орчинг бүрдүүлсэн байдал
- Тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, лаборатори, урлангийн хангалт, ашиглалтын байдал
- Бие даан болон багаар ажиллах орчны хангалт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- *БС – ийн өөрийн эзэмшилд хичээлийн 2 байр, 5 лабораторитай.*
- *2017 онд МУИС –ийн Төв номын сан 700 гаруй суудалтай, 360.0 мянга гаруй хэвлэмэл ном, бусад цахим сантайгаар ашиглалтанд орсон.*

- БС- ийн дэргэд 14.0 мянга гаруй хэвлэмэл номын фондтой бие даасан салбар номын сантай.
- 2018 онд БС- ийн тэнхим хооронд ашиглах 40 суудал бүхий дадлагын 2 танхимыг шинээр ашиглалтанд оруулсан байна.
- 2015-2017 онд БС –иас сургалтын орчныг сайжруулахад зориулж жилд дунджаар 586.9 сая. ₮ зарцуулсанаас хичээлийн байрны их засварт 78.3% буюу 459.8 сая. ₮, тавилга, эд хогшил худалдан авахад 5.7% буюу 33.5 сая. ₮, сургалтын тоног төхөөрөмж худалдан авахад 16% буюу 93.6 сая. ₮ тус тус зарцуулсан байна.
- 2013-2017 онд 351.1 сая. ₮ -ийн сургалтын тоног төхөөрөмж худалдаж авсаны 80.0% ийг (280.9 сая. ₮) зөвхөн сүүлийн 3 жилд худалдан авч, хичээлийн анги танхимуудыг сургалтын техник хэрэгслээр бүрэн тоноглогосон байна.
- МХТ – ийн багш, ажилтнууд шаардлагатай тавилга, сургалтын тоног төхөөрөмж, техник хэрэгслээр бүрэн хангагдсан байна.

Анхаарах асуудал:

- Хичээлийн IV байр ихээхэн хуучирч, ашиглалтын стандарт шаардлага хангахгүй болсон.

Зөвлөмж:

- Хичээлийн IV байрыг шинээр барьж байгуулах ажлыг эхлүүлэх;
- Оюутны бие дааж болон багаар ажиллах орчин, нөхцлийг сайжруулах;
Үндсэн багш нарын албан хэрэгцээнд зориулагдсан зөөврийн компьютерийн хангамжийг сайжруулах

2.2 Сургалтын хэрэглэгдэхүүн, хэрэгсэл

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Программ хангамж, симуляци, виртуал лабораторийн хэрэглээ, хүртээмж
 - Хичээл практикийн материаллаг нөөц, хэвлэмэл үзүүлэн, тараах материал, хэрэглэгдэхүүний хүртээмж, хэрэглээ
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмжийн хүртээмж

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- БС- ийн хэмжээнд өмнөх магадлан итгэмжлэлээс хойш хүчин чадал сайтай 85 компьютертай 3 лабораторийг шинээр байгуулсан байна.
- Хөтөлбөрийн онцлогт тохирсон SPSS21, STATA11, SAP ERP, Eviews 9 гэх зэрэг 10 гаруй программыг туршилтын хувилбараар ашиглаж байна.

Анхаарах асуудал:

- *Семинар, лабораторийн хичээлд хэрэглэх гарын авлага, хэвлэмэл үзүүлэн, тараах материалын хүртээмж, хэрэглээ төдийлөн хангалттай бус байна.*

Зөвлөмж:

- *Семинар, лабораторийн хичээлийн гарын авлага, хэвлэмэл үзүүлэн, тараах материалыг шинэчлэн боловсруулж, сургалтад өргөн ашиглах;*
- *Албан ёсны лицензтэй программ хангамжийг нэмэгдүүлэх;*

2.3 Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт мэдээллээр тогтмол, чанартай хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- *Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн судалгаа, хүртээмж, хэрэглээ*
- *Виртуал, дижитал видео, аудио болон бусад цахим эх үүсвэрүүдийн байдал*
- *Цахим орчны хүртээмж, хэрэглээ*
- *Сургалт, судалгааны лицензтэй программын ашиглалтын байдал*

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- *2016 онд МУИС –ийн номын сангийн “Коха” системд өргөтгөл хийгдсэнээр сургалт, судалгааны цахим эх үүсвэрүүд болон EBSCO, JSTOR, Springer зэрэг онлайн мэдээллийн 16 санг ашиглах өргөн боломжийг нээж өгсөн байна.*
- *Сургалтын цахим орчны хүртээмж мэдэгдэхүйц сайжирсан байна.*

Анхаарах асуудал:

- *БС – ийн салбар номын санд маркетингийн мэргэжлийн 221 нэрийн 1786 ш ном байгаа нь нийт номын фондын 11.8%-ийг эзэлж байна. Тэдгээрийн 37 нэрийн 279 ш ном нь 2010-2013 онд, 6 нэрийн 62 ш ном нь 2015 оноос хойш тус тус хэвлэгдсэн байна. 2013-2017 онд БС ном сурах бичгийн зардалд нийт 206,1 сая. ₮ төсөвлөсөн боловч ердөө түүний гуравны нэг хэсгийг буюу 68.1 сая. ₮ буюу зарцуулсан байна. Эндээс үзэхэд номын фондыг шинэ ном, сурах бичгээр сэлбэж баяжуулах ажил удаашралтай, нэг нэрийн номыг маш цөөн тоо ширхэгээр худалдаж авдаг зэрэг дутагдал ажиглагдаж байна.*
- *Сургалт, судалгаанд сургалтын программын туршилтын хувилбар (trial version) – ыг ихэвчлэн хэрэглэж байна.*

Зөвлөмж:

- *Маркетингийн мэргэжлийн номын фондыг сүүлийн үеийн шинэ ном, сурах бичгээр баяжуулах, номын санд нэг сурах бичгийг худалдан авах тоо ширхэгийг*

нэмэгдүүлэх замаар оюутнуудын мэргэжлийн ном, сурах бичгийн хүрэлцээ, хангамжийг сайжруулах;

- БС-ийн салбар номын санд маркетингийн мэргэжлийн е - ном, сурах бичгүүдийн цахим сан бий болгох;
- Маркетинг, зар сурталчилгааны мэргэжлийн сэтгүүлийн захиалгыг нэмэгдүүлж, суралцагчдад хүртээмжтэй ашиглуулах;
- Оюутнуудын ном, сурах бичгийн онлайн эх үүсвэрийн ашиглалтыг сайжруулах
- БС-ийн номын сангийн мэргэжлийн ном, сурах бичгийн фондын баяжуулалт хийх дүрэм, журмыг өөрчлөн сайжруулах;
- Сургалт, судалгааны лицензтэй программыг ашиглах;

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

3.1 Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдал
- Хөтөлбөрийн нэгжийн /гэнхим, профессорын баг, хөтөлбөрийн хороо/ шийдвэр гаргалт, хэрэгжилтийн үнэлгээнд багш, суралцагчдын оролцоог нээлттэй, ил тод хангасан байдал
- Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай дүрэм, журмуудын хэрэгжилт
- Урт болон богино хугацааны төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлан, ахиц өөрчлөлтийн дүн шинжилгээ механизм
- Санал, гомдол хүлээн авах, хариу өгөх үйл ажиллагаа, систем бүрдсэн байна.
- Хөтөлбөрийн багш, ажилтнуудын хүний нөөцийн судалгаа, шинжилгээ, хөгжүүлэх ажлын үнэлгээ, гүйцэтгэлийн болон үр дүнгийн урамшууллын хэрэгжилт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын хувьд өмнөх магадлан итгэмжлэл хийгдсэн үеэс хойш 2013- 2017 онд хөтөлбөрт суурилсан бүтцээр, 2017 оны 04 –р сараас эхлэн тэнхимийн хэлбэрт шилжиж 2 удаа өөрчлөгдсөн байна. Мөн энэ хугацаанд МУИС–тай ХҮДС (хуучин нэрээр)-ийг нэгтгэх, салгах зохион байгуулалтын өөрчлөлт хийгдсэнтэй уялдан маркетингийн хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтанд тодорхой өөрчлөлт гарчээ.
- Сургалтын үйл ажиллагаанд SiSi системийг амжилттай нэвтрүүлснээр сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдлыг бүрэн хангасан байна.
- 2015, 2016 онд хөтөлбөрийн оюутнуудын суралцах үйл явцад гарсан тодорхой ахиц дэвшилийг үнэлж, олон улсын Peregrine байгууллагаас тусгай шагналыг жил дараалан олгосон байна.
- МХТ-ийн 2016-2024 оны стратегийн төлөвлөгөө боловсруулж, гүйцэтгэлийг (KPI) 15 шалгуур үзүүлэлтээр хэмжэдэг болжээ.
- Хөтөлбөрийн удирдлагын зүгээс сургууль, тэнхимийн мэдээлэл, харилцааны систем(<https://sisi.num.edu.mn>), вэб хуудас (www.num.edu.mn, www.bs.num.edu.mn www.marketing.bs.num.edu.mn), и-мэйл, олон нийтийн сүлжээ(BS.Marketing hutulburiin tugsugchid, Marketing hutulburiin oyutnii group зэрэг Facebook page), тэнхимийн самбар, гар утас гэх зэрэг мэдээлэл, харилцааны сувгуудыг ашиглахын зэрэгцээ оролцогч, сонирхогч талуудын идэвхи, оролцоог нэмэгдүүлж, тэдэнтэй эргэх холбоог тогтоох эхлэлүүд тавигдсан байна.

Анхаарах асуудал:

- Урт болон богино хугацаагаар ажлаа төлөвлөж, хэрэгжүүлэх ажлууд тогтмолжсон боловч тэдгээрийн өөрчлөлт, ахиц дэвшилд үнэлэлт дүгнэлт өгч, тухай бүр нь удирдлагын шийдвэрт тусгах тал дээр сул анхаардаг байдал ажиглагдаж байна.
- Үндсэн багш нарын сургалтын ачаалал өндөр учраас тэдний судалгааны ажлыг гүйцэтгэх цагийн боломж хязгаарлагдмал байна.
- Үндсэн багшийн тоо цөөрч, цагийн багшийн тоо нэмэгдсэн байна.

Зөвлөмж:

- Тайлан, мэдээллийн нэгдсэн “D-Space” системийг бүрдүүлэх;
- Хөтөлбөрийн нэгж болон багш нарын KPI-ийг дүгнэхэд шаардлагатай тайлан мэдээллийн нэгдсэн цахим сантай болох;
- Хөтөлбөрийн нэгжийн шийдвэр гаргалтанд хөтөлбөрийн оролцогч, сонирхогч талуудын санал асуулгын дүн, зөвлөмжийг тусгаж байх;
- Санал, гомдол хүлээн авах, хариу өгөх системийг бүрдүүлэх;
- Хөтөлбөрийн багш, ажилтнуудын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, шалгуур хангасан хүнийг багш, ажилтны нөөцөд бүртгэж байх;
- Багшийн нөөцөд бүртгэгдсэн эрдмийн зэрэг цолтой, мэргэшсэн хүмүүсийг бодлогоор дэмжих;

- Үндсэн багш нарын сургалтын ачааллыг нормоос хэтрүүлэхгүй байх, тэдэнд судалгааны ажил гүйцэтгэх боломжийг олгох;

3.2 Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгааны давтамж
- Хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхжүүлэлтийн арга хэлбэр, хүртээмж, үр нөлөө

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- *Маркетинг худалдааны тэнхим нь хөтөлбөрийн идэвхижүүлэлтийг “Мэргэжил (хөтөлбөр) сурталчлах” болон “Нээлттэй хаалганы” өдөрлөг зохион байгуулах, “Боловсролын үзэсгэлэн, яармаг”-т оролцох, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр сурталчлах, мэргэжлийн чиглэлээр хурал, форум зохион байгуулах, оролцох, хэвлэн нийтлэх зэрэг олон хэлбрээр нийт 18 ажил зохион байгуулсан байна.*

Анхаарах асуудал:

- *Маркетингийн мэргэжилтний зах зээлийн эрэлт ба нийлүүлэлтийн нарийвчилсан судалгаа хийгдээгүй байна.*
- *Хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхжүүлэлтийн арга хэмжээний хүртээмж, үр нөлөөг тооцох тодорхой ажил хийгдээгүй байна.*

Зөвлөмж:

- *Хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангахуйц идэвхжүүлэлтийн нарийвчилсан хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, түүний хэрэгжилт, үр дүнг нь тогтмол тооцож байх;*
- *Хөтөлбөрийг төлөвлөх, шинэчлэхэд төгсөгч, ажил олгогч, мэргэжлийн холбоод, магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн төлөөллөөс өгсөн санал, зөвлөмжийг тусгаж байх;*
- *Хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхжүүлэлтэнд интернэт, дижитал болон социал медиа маркетингийн аргуудыг өргөн ашиглах замаар оролцогч, сонирхогч талуудын анхаарал татахуйц, үр дүнтэй, сонирхолтой шинэ, дэвшилтэт хэлбрүүдийг нэвтрүүлэх;*

3.3 Төгсөлтийн дараах бодлого

Хөтөлбөр нь төгсөгчидтэйгээ байнгын эргэх холбоотой, тэдний мэргэжлийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулж, төгсөгчид нь суралцаж буй

суралцагчдад мэргэжлийн чиглэлээр ажиллахад нь зөвлөн тусладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Төгсөгчдийн карьерын өсөлтийн судалгаа
- Үргэлжлүүлэн суралцагчдын хувь хэмжээ
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах бодлого, төлөвлөгөө, хамрагдсан байдал
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны тогтмолжсон байдал

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2017 онд явуулсан төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаанд МУИС – ийн БС- ийг 2012 – 2016 онуудад төгссөн нийт 396 төгсөгч хамрагдсанаас 12.4 хувийг зөвхөн маркетингийн хөтөлбөрөөр төгсөгчид эзэлж байв.
- 1996 оноос маркетингийн мэргэжлээр 25 удаагийн төгсөлтөөр нийт 460 хүн төгссөн. Төгсөгчдийн 46% нь ажил эрхэлж байгаагийн 85% нь мэргэжлээрээ ажилладаг.
- 2014-2015 онд төгсөгчдийн 31.6%, 2015-2016 онд төгсөгчдийн 23.5% нь тус тус гадаад, дотоодын их сургуулиудад үргэлжлүүлэн суралцаж байгаагаас үзэхэд сүүлийн жилүүдэд нийт төгсөгчдийн багагүй хэсэг нь цааш үргэлжлүүлэн суралцдаг байна.
- Зарим төгсөгчид хөтөлбөрөөр суралцаж буй 1, 2-р түвшний оюутнуудад мэргэжлийн зөвлөгөө өгөх, мэргэжлийн олимпиад, тэмцээнийг ивээн тэтгэх, шүүгчээр ажиллах, үйлдвэрлэлийн дадлага удирдах, төгсөлтийн шалгалтын комиссоор ажиллах зэргээр хөтөлбөрийн нэгжтэй хамтран ажиллаж байна.
- БС – ийн дэргэдэх “Төгсөгчдийн холбоо” нь МУИС – ийн хэмжээнд тэргүүний холбоогоор удаа дараа шалгарч, турилага хуримтлуулсан төдийгүй уг холбооноос санаачлан 2011 оноос хойш “Бизнесийн удирдлагын дээд курс” сургалтыг жилд тогтмол 1 удаа амжилттай зохион байгуулж иржээ.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн хүрээнд төгсөлтийн дараах нэгдсэн бодлого тодорхой бус байна.
- Өөрийн төгсөгчидтэй байнгын эргэх холбоо тогтоох, тэднийг давтан сургалтанд хамруулах ажлын төлөвлөгөө байхгүй байна.
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах талаар тодорхой ажлууд хийгдэж эхлээгүй байна.

Зөвлөмж:

- Төгсөгчдийн карьерын өсөлтийн болон үргэлжлүүлэн суралцагчдын судалгааг тогтмол хийж байх;
- Хөтөлбөрийн хүрээнд төгсөлтийн дараах нэгдсэн бодлогыг тодорхойлох;

- Төгсөгчидтэй байнгын эргэх холбоо тогтоох, тэднийг давтан сургалтанд хамруулах зохимжтой арга хэлбэрүүдийг хамтран боловсруулж, хэрэгжүүлэх;
- Төгсөгчдийн холбоотой хамтран ажиллах үйл ажиллагааг идэвхжүүлэх;

3.4 Олон улсын харилцаа, хамтын ажиллагаа

Олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн тайлан, дүгнэлт
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоо
- Олон улсын хурал семинар, судалгаа болон бусад арга хэмжээнд оролцсон тоо, үр дүн, ач холбогдол

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2013 – 2017 онд гадаадын байгууллага, их дээд сургуулиас 5 зочин уригдаж, богино хугацааны сургалт, семинар хамтран зохион байгуулсан байна.
- Хөтөлбөрийн багш нар олон улсын хурал семинар, судалгаа болон бусад арга хэмжээнд идэвхитэй оролцдог.
- 2015 онд БНХАУ – д нэг, 2018 онд Австрали улсад нэг багш докторын тэтгэлэгт хөтөлбөрт тус тус хамрагджээ.

Анхаарах асуудал:

- 2013 онд БНСУ –ын Чунвонь их сургуультай хамтран ажиллах санамж бичгийг үзэглэж, багш, оюутны солилцоо, хамтарсан судалгааны ажил хийхээр тохиролцсон боловч одоогоор тодорхой ажлууд хийгдээгүй байна.
- Олон улсын оюутан солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт суралцагчдын хамрагдалт хангалтгүй байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн удирдлагын зүгээс олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоох талаар цаашид идэвхи, санаачилгатай ажиллах;
- БНСУ-ын Inha, Австралийн Bolongong, БНХАУ-ын Шанхайн их сургуулиудтай хамтын ажиллагааны гэрээг байгуулж, хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Оюутан солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт оюутан, суралцагчдын хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр санаачлагатай ажиллах;
- Хөтөлбөрөөр суралцах гадаад оюутны тоог нэмэгдүүлэх;

3.5 Дотоод хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нь мэргэжлийн холбоод, үйлдвэр, үйлчилгээний байгууллагууд, ажил олгогч эздийн холбоо, төрийн болон ТББ-уудтай хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хамтран ажиллах гэрээ, хэлцэл, ажлын үр дүн
- Хэрэгжүүлж буй ажлуудын тайлан, дүгнэлт
- Хамтын ажиллагааны арга, туршлага
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо үр дүн /багш, суралцагчдын зүгээс/

Шалгуурыг хангасан байдал: **Бүрэн хангасан**

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нь сүүлийн 5 жилд МҮХАҮТ, ММХ, ННХ гэх зэрэг мэргэжлийн 3 холбоо, Монгол-Японы төв, ГЕГ гэх зэрэг 3 байгууллага, 4 үйлдвэр, аж ахуйн газруудтай хамтран сургалт зохион байгуулах, судалгаа хийх, мэргэжлийн олимпиад тэмцээн зохион байгуулах зэргээр хамтран ажилласан байна.
- 2012-2017 онд хөтөлбөрийн багш нар дотоодын 20 гаруй байгууллагатай хамтран 18 гэрээт болон төсөлт ажлыг гүйцэтгэсний 38.8% -ийг нь зөвхөн 2017 онд хэрэгжүүлсэн нь сүүлийн жилүүдэд дотоод хамтын ажиллагаа ихээхэн өргөжиж буйг харуулж байна.
- Мэргэжлийн холбоод, үйлдвэр, үйлчилгээний байгууллагууд, ажил олгогч эздийн холбоо, төрийн болон ТББ-уудтай хамтран ажиллах үйл ажиллагаа тогтмолжсон байна.
- Хөтөлбөрийн багш нар сүүлийн 3 жилд сургалт, заах арга зүйн 4 арга туршлагаас суралцсан байна.
- 2014-2017 онд хөтөлбөрийн багш нар 10 гаруй байгууллага, давхардсан тоогоор 570 гаруй хүнийг хамруулсан нийгэмд чиглэсэн 11 төрлийн сургалт, үйлчилгээ үзүүлжээ.

Зөвлөмж:

- Мэргэжлийн холбоод, үйлдвэр, үйлчилгээний байгууллагууд, ажил олгогч эздийн холбоо, төрийн болон ТББ-уудтай хамтран ажиллах гэрээ хэлцэл байгуулж, тогтвортой хамтран ажиллах;
- БС-ийн дэргэдэх “Бизнес консалтинг төв” –тэй хамтран богино хугацааны модуль сургалтуудыг зохион байгуулах;
- Дотоод хамтын ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, түүний хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж байх;

- *Хөтөлбөрийн нэгжээс нийгэмд чиглэсэн тодорхой ажлуудыг санаачлан хэрэгжүүлж, түүний үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарч ажиллах;*

3.6 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Төсөв, санхүүгийн бие даасан байдлын хөгжил
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв
- Төр хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалт
- Төсвийн уламжлалт бус эх үүсвэр, бүрдүүлэлт, хуваарилалт, санхүүжилт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- *Хөтөлбөрийн санхүүжилт БС –ийн үйл ажиллагааны зардлын нэгдсэн төсөв болон МУИС – ийн “Багшийн хөгжлийн сан” гэсэн 2 эх үүсвэртэй болсон байна.*
- *Хөтөлбөрт хуваарилагдсан төсвийг захиран зарцуулах эрх тэнхимд шилжсэнээр төсөв, санхүүгийн бие даасан байдал тодорхой хэмжээнд хангагдсан байна.*
- *Хөтөлбөрийн удирдлага “Багшийн хөгжлийн сан” -аас тэнхимд хуваарилагдсан хөрөнгийн хэмжээ нэмэгдэхийн зэрэгцээ захиран зарцуулах эрхтэй болжээ.*
- *2014-2017 онд хөтөлбөрийн сурталчилгаанд жил бүр 500.0 мян. ₮-ийг зарцуулсан байна.*
- *Багш, профессорын судалгааны суурь зардлыг жил бүрийн төсөвт тусад нь тусгаж, зарцуулдаг болжээ.*

Анхаарах асуудал:

- *Багшийн цалин хөлс, болон тоног төхөөрөмжийн зардлыг БС – ийн дүнгээр бүртгэдэг тул нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоог хөтөлбөрөөр нарийвчлан гаргах боломжгүй байна.*
- *Хөтөлбөрийн төсөвт оруулж буй төр, хувийн хэвшлийн дэмжлэг төдийлөн сайнгүй байна.*

Зөвлөмж:

- *Хөтөлбөрийн нэгжээс жил бүр хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөнд шаардагдах зардлыг тусгайлан сайтар төлөвлөж, БС- ийн нэгдсэн төсөвт суулгаж байх;*

- Тэнхимд хуваарилагдсан төсвийн зарцуулалтыг жил бүр тайлагнаж, үр дүнг нь хамт олноороо хэлэлцэж байх;
- Багш, суралцагчийн хөгжил болон суурь судалгааны зардлын санхүүжилтийн норм, нормативыг үндэслэлтэй тогтоож, мөрдөх;

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

4.1 Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Суралцагч элсүүлэх эрх зүйн зохицуулалтад хөтөлбөрийн онцлогт нийцсэн шалгуурыг тусгасан байдал
- Элсэгчдийн ЕШ-ийн дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа
- Шинээр элссэн суралцагчдыг чиглүүлэх сургалтад хамруулж, мэдээлэл, гарын авлагаар хангасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Элсэгчдийн ЕШ-ийн дундаж оноонд судалгаа хийж, элсэгчдийн ерөнхий хандлагад анализ хийн хандлагыг тодорхойлдог.
- Элсэгчдэд мэргэжлийн чиглүүлэг өгөх ажлыг тогтмол зохион байгуулж, тараах материал, гарын авлага, материалаар тогтмол хангадаг.
- Мэргэжил сурталчлах өдөрлөг тогтмол зохион байгуулж мэргэжлийн чиг баримжаагаа тодорхойлох боломжийг сурагчдад олгодог.
- Элсэгчийг чиглүүлэх үйл ажиллагаа, мэргэжил сонголтын үйл явцад дүгнэлт хийн мэргэжил сонголтын хугацааг хэт хойно биш хийлгэх зорилгоор оюутанд тохиромжтой хугацааг тогтоосон.
- Эхний хичээлийн жилийн суурь мэдлэг олгох хугацаанд хөтөлбөрийн онцлогт нийцсэн шалгуур буюу маркетингийн суурь сэтгэлгээ, оюутны зан чанарын онцлог, хүсэл сонирхолд тулгуурлан суралцагчид тохирох мэргэжлээ сонгоход нь зөвлөгөө, дэмжлэг үзүүлж ажилладаг.

Зөвлөмж:

- Элсэгчдийг тухайлан мэргэжлийн чиглэлдээ татах үйл ажиллагааг багш нарын санаачилгын түвшинд хийж байгааг албажуулах, тогтмолжуулах;

4.2 Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчдад суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогмол, чанартай үзүүлдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, график, үр дүн
- Зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, сургалтын менежер, арга зүйч, байрны багш, эмч, сэтгэл зүйч нарын үйлчилгээний чанарын үнэлгээ, сайжруулалт
- Бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйн /зан үйл, зөрчил шийдвэрлэх, эрүүл аж төрөх г.м/ чиглэлүүдээр сургалт явуулж, ур чадвар олгодог байдал
- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлыг үнэлдэг байдал
- Суралцагч, төгсөгчдөд хөдөлмөрийн биржийн үйлчилгээ үзүүлдэг байдал
- Суралцагчийн судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг дэмжин тусласан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Анги бүрт зөвлөх багш томилогдон ажилладаг, жил бүр багш нарын зөвлөгөө өгөх хуваарь тодорхой гаргаж, мөрддөг.
- Багш нар Мэргэжлийн уралдаан тэмцээнүүдэд оюутнуудаа удирдан чиглүүлэх, зөвлөх ажлыг тогтмол гүйцэтгэдэг.
- Суралцагчдын гүйцэтгэсэн сайн дурын ажлыг тухайд оюутанд тэтгэлэг олгоход шалгуур болгодог, төгсөлтийн тодорхойлолтод тусгадаг тул энэ нь оюутны идэвх санаачлагыг эрчимжүүлдэг.
- Сургуулийн нэгдсэн хүрээнд зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- Зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, сургалтын менежерүүдийн үйлчилгээний чанарын үнэлгээг хийдэггүй тул үнэлгээ өгөх, тэдний сайн гүйцэтгэлийг сэдэлжүүлэхэд анхаарах;
- Академик чиглэлээс бусад чиглэлээр зөвлөгөө өгч буй байдлыг эрчимжүүлэх, энэ талын төлөвлөгөө гаргаж ажиллах; (тэнхим + бусад нэгж+баги)
- Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж, тэнхим, багш нарын ажлын зааг тодорхой байх;
- МУИС-ийн хэмжээнд нэгдсэн сургалт явуулах ажил дутмаг.
- Оюутны нийгмийн үйл ажиллагааг үнэлдэг тогтсон систем, журам шаардагдаж байна.(Одоогоор тодорхойлолт дээр нь бичиж байна. Тэтгэлэгт шалгуур үзүүлэлт болгож байна.
- Сургалтын алба нэгдсэнээр оюутны үйлчилгээ зарим талаар холдох магадлалтай. Тухайлбал: Сурлагаар тааруу, идэвх сул болон сургалт завсардаж байгаа оюутны тухай

мэдээллээр тэнхмийг хангаж ажиллахгүй мэдээллийн урсгал саарвал оюутан анхаарлаас орхигдох асуудал гарах магадлалтай тул үүнд анхаарах;

Зөвлөмж:

- *Зөвлөх багшийн ажиллах журам боловсруулах;*
- *Зөвлөх үйлчилгээний чанарыг үнэлэх шалгуур үзүүлэлт гаргах, чанарын үнэлгээг тогтмол хийж, зөвлөх багш, сургалтын туслах ажилтны ажлыг үнэлэх, үнэлгээ ба урамшууллын системтэй холбох;*
- *Оюутанд чиглэсэн бие хүний төлөвшил, харилцаа, ёсзүй, эрүүл аж төрөх ёс, ажлын байранд бэлтгэх чиглэлээр нэгдсэн байдлаар сургалт явуулах, төлөвлөгөөтэй ажиллах;*
- *Энэхүү үйл ажиллагаа хэрхэн явагдах процессийн зураглал гаргаж оюутан, багшийг мэдээллээр хангах;*

4.3 Оюутны байгууллагад үзүүлэх дэмжлэг

Оюутны байгууллагаас санаачилсан нийгэмд үзүүлэх үйлчилгээг дэмжин хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Оюутны сайн дурын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, дэмжсэн байдал
- Оюутны байгууллагын үйл ажиллагааг явуулах төсөв, клубын үйл ажиллагааг дэмжих санхүүжилттэй байх, зориулалтын дагуу зарцуулдаг байдал
- Оюутны байгууллагын зүгээс санхүүгийн зарцуулалтаа ил тод тайлагнадаг байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- *Оюутны байгууллага, сайн дурын клубүүдийн үйл ажиллагааг санхүүжилт олгох, ажиллах өрөө тасалгаа, бусад боломжоор хангах зэргээр дэмжиж ажилладаг.*
- *Багш нар оюутны клубийн үйл ажиллагааг чиглүүлж, зөвлөн туслах үйл ажиллагааг байнга идэвхтэй явуулдаг.*

Анхаарах асуудал:

- *Оюутны клуб үйл ажиллагааны тайлангаа тавьдаг. Бизнесийн сургуулийн оюутны холбоо нээлттэй үйл ажиллагаатай, харин нэгдсэн холбооны засаглал, санхүүгийн ил тод байдлын хувьд оюутнууд сэтгэл дундуур байдаг. Энэ нь оюутнуудад өгөх үлгэр дуурайл, ёс суртахнууны үлгэрлэл тал дээр асуудалтай гэж оюутнууд дүгнэж буй тул анхаарах;*

Зөвлөмж:

4.4. Суралцагчийн урамшууллын тогтолцоо

Суралцагчдын амжилтыг хөхүүлэн дэмжих урамшууллын системтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо
- Суралцагчдын үзүүлсэн амжилтууд
- Сургуулиас үзүүлж буй урамшуулал, дэмжлэг

Шалгуурыг хангасан байдал: **Бүрэн хангасан**

Онцлог зүйл/Туршлага:

- *Оюутныг дэмжих, урамшуулах ажлуудыг сургуулийн зүгээс болон байгууллагуудтай хамтран байнга хэрэгжүүлж хэвшсэн.*
- *Оюутныг тэтгэлэгт жигд хамруулах нэгдсэн журам, процедур бий болгох тал дээр анхаарч МУИС-ийн Оюутан төгсөгчдийн хэлтэс нь тэтгэлгийн журмаа шинэчилсэн.*

Зөвлөмж:

- *Тэтгэлэгт хамрагдсан оюутны тоог тодорхойлох, түүний тайланг гаргах, анализ хийх хүртээмжид дүн шинжилгээ хийж хэвших;*

4.5. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэсэн байдал
- Шилжилт хөдөлгөөний судалгаа, дүгнэлт
- Шилжилт хөдөлгөөнийг зохицуулж буй дүрэм, журам, гэрээний хэрэгжилт, суралцагчийн эрх ашгийг дээдэлсэн байдал

Шалгуурыг хангасан байдал: **Бүрэн хангасан**

Онцлог зүйл/Туршлага:

- *Элсэлт бүртгэлийн хэлтэс шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэдэг.*
- *Дүрэм журам тодорхой, нэгдсэн байдлаар шилжилт хөдөлгөөнийг шийддэг.*
- *Суралцагчийн эрэлт хэрэгцээ, эрх ашигт нийцүүлэхийг чухалчилдаг.*
- *Шилжилт хөдөлгөөнд судалгаа хийж дүн шинжилгээ хийдэг.*

Анхаарах асуудал:

- Шилжилт хөдөлгөөний дүн шинжилгээ, шилжилт хөдөлгөөний шалтгаан зэрэг мэдээллээр тэнхим хүргэх зэргээр нэгдсэн судалгаа, дүн шинжилгээгээр бусад нэгжийг хангаж ажиллах;

Зөвлөмж:

- Шилжилт хөдөлгөөн хийж буй оюутантай ганцаарчилсан ярилцлага хийх;
- Шалтгааныг тодруулах;
- МУИС-ийн нэгдсэн судалгаанаас мэдээлэл авч байх;
- Хэрхэн уялдаж ажиллах тухайд процессийн зураглал гаргах, мөрдөх;

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

5.1 Багшийн сонгон шалгаруулалт, албан тушаал, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлого: тушаал, урамшууллын бодлого Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна. сонгон шалгаруулалт, хөгжүүлэлт, төлөвлөлт, хэрэгжилт
- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин
- Багш суралцагчдын тооны зохистой харьцаа
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг мөрддөг байдал
- Гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилан багш нарыг урамшуулдаг байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хүний нөөцийн бодлого зохицуулалтын хүрээнд “МУИС-д профессор багш ажиллуулах журам” (МУИС-ийн Захирлын тушаал. 2014.12.22 Дугаар А/414), Боловсрол, шинжлэх ухааны яамнаас (Сайдын тушаал 2014.04.28 А/174) баталсан “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”, МУИС-ийн “Хөдөлмөрийн дотоод журам”, МУИС-ийн Шагнал урамшууллын нийтлэг журам”(2017.05.18, Дугаар А/127) зэрэг дүрэм жуомын хүрээнд нэгдмэл байдлаар зохицуулалт хийдэг.
- Маркетингийн хөтөлбөрт зөвхөн маркетингийн чиглэлийн бус бусад чиглэлийн профессор багш нар хичээл заадаг бөгөөд нийт дүнгээрээ эрдмийн зэрэг цол

өндөртэй, туршлага сайтай багш нар зааж байгаа нь тайлан мэдээлэл болон багш нарын насны бүтцээр тодорхойлогдож байна.

- *Багшлах бүрэлдэхүүний зэрэг цолыг дээшлүүлэх тухайд бодлого хэрэгжиж байгаа нь үр дүнгээ өгч байна.*

Анхаарах асуудал:

- *Багш нар С цагийн ачаалал ихтэй.*

Зөвлөмж:

- *Ажилтнуудын ажил үүргийг зохистой хуваарилах, үйл явцын зураглалыг гаргах замаар багш нарын техник ажлыг багасгахад анхаарах;*
- *Зарим төрлийн захиргааны ажлыг тухайн холбогдох алба, нэгж хариуцан ажиллах, захиргааны ажилтнуудын мэдлэг, ур чадварыг давхар анхаарах;*

5.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Багшийн мэргэжил; заах арга зүйн ур чадвар; эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшин; суралцах хэрэгцээг тодорхойлох судалгааг тогтмол хийдэг байдал
- Багшийн хөгжлийн хөтөлбөр, хэрэгжилт, дүн шинжилгээ, сайжруулалт
- Багшийг үе шаттай хөгжүүлж, урт богино хугацаанд мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлж чадавхжуулдаг байдал
- Гадаад, дотоодод туршлага судлуулсан байдал
-

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- *Багшийн хөгжлийн хөтөлбөрийг 2019-2020 он хүртлэх хугацаагаар боловсруулж үүнийхээ хүрээнд, загвар гаргасан: Үүндээ Багшийн сургалт, судалгаа, хувь хүний хөгжлийн чиглэлээр албан тушаалын зэрэглэл бүрээр шаардлагатай ур чадваруудыг тодорхойлсон. Сургууль зорилго, зорилтоо дэмжиж ажиллах хүрээнд багшийн хөгжлийн хөтөлбөртөө суурилан багш бүр өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж байгаа бөгөөд үүний үндсэн дээр тэнхим болон сургуулийн багш хөгжлийн төлөвлөгөө илүү тодорхой болгох тухайд энэ хичээлийн жил анахаарч ажиллаж эхлээд байна.*
- *Багшийн хөгжилд зориулан Бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлбөрийн 2 хувийг зарцуулахаар шийдвэрлэж сан үүсгэсэн. Энэхүү сан нь Бизнесийн сургууль болон МУИС-ийн нэгдсэн гэсэн 2 түвшинд сан байгуулж багш нарыг сургах, хөгжүүлэх, гадаад дотоодын туршлага судлуулахад мөн ихээхэн анхаарч ажиллаж байна.*

- МУИС-ийн “Багшийн хөгжлийг дэмжихэд зориулсан төсвийг зарцуулах зөвлөмж”-ийн дагуу багшийг хөгжил, дэмжлэгийн асуудлыг шийдвэрлэж байна.

Анхаарах асуудал:

- Багш, ажилтнуудын тухай нэгдсэн мэдээлэл дутмаг байна.

Зөвлөмж:

- Тайланд багш нарыг хөгжүүлсэн, сургалтад хамруулсан тухай дурьдсан боловч, мэдээллийн баазтай болох замаар энэ хүрээнд мэдээллийг нэгтгэх, анализ хийх;

5.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, патентийн тоо
- Захиалгат төсөл, гэрээт ажилд оролцсон байдал
- Судалгааны ажлын үр дүнгээр хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүй; судалгааны ажил шинэчлэгдэн хөгжсөн байдал
- Үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Эрдмийн ажлыг эрчимжүүлэх тал дээр бодлого зохицуулалт, дэмжлэг сайтай.
- Багш нарын бүтээлийг зөвхөн сургуулийн хэмжээнд биш мэргэжлийн салбарын хэмжээнд анхаарч бусад их дээд сургуулиудын багш нарын хамтын ажиллагааны хүрээнд Мэргэжлийн сурах бичиг орчуулах ажлыг манлайлан ажиллаж бүтээлүүд гаргаж байна. Тухайлбал 9 их дээд сургууль, байгууллагын багш, мэргэжилтнүүд болон мэргэжлийн холбооны гишүүдийн хамт “Маркетингийн удирдлага”-ын сурах бичгийг албан ёсны эрхтэйгээр орчуулж оюутан суралцагч, салбарынхны хүртээл болгосон. Одоо “Intergated Marketing Communication” номын орчуулгын ажилдаа мөн мэргэжилтнүүдтэй хамтран ороод байна. Энэ нь салбартаа үнэ цэн авчрах томоохон ажил болж байна.
- Багш нарын судалгааны ажлууд сургалтын агуулгад тусгалаа олдог бөгөөд багш нарын бүтээлүүд зөвхөн сургуулийн хүрээнд бус бусад сургуулиудын суралцагчдын хүртээл болдог.

Анхаарах асуудал:

- Багш нарын цагийн бодит ачаалал ЭШ-ний ажил хийх цаг хугацаа гаргахад нөлөөлж байгаа тул хэрхэн зохицуулах тухайд гаргалгаа хийж буй эсэхэд анхаарах;

- Сургалтын алба нэгтгэгдсэнтэй холбоотой ажлууд тэнхим рүү шилжих магадлал ихтэй, Орон тооноос хамаарч багшийн ачаалал хэтрэх байдал ажиглагдаж байна.

Зөвлөмж:

- Багш нарын ЭШ-ний бүтээл, мэргэжлийн үйл ажиллагааны тухай мэдээллийн сантай болох, ингэснээр түүнд анализ хийх боломж бүрдэх юм. Тухайлбал *Воркер*-ийн гэх мэт ямар нэгэн загвар дээр суурилан мэдээллийн бааз үүсгэн анализ хийх нь ахиц дэвшилийг харах, эрдмийн ажлыг багш нар ямар чиглэлд түлхүү хийж гүйцэтгэж, ямар чиглэл орхигдож байгаа зэргийг дүгнэж цэгнэх боломж бий болгох юм. Мөн түүнчлэн багш нарын жигд хийж буй эсэхийг дүгнэх бололцоо мэдээллийн баазын тусламжтайгаар бий болно.

5.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Багшийн хөндлөнгийн үнэлгээ /Аттестатчлал, эрэмблэлт, чансаа тогтоолт/
- Сургалтад ашиглаж буй сургах/заах аргын үр дүн, үр нөлөөний судалгаа
- Тайлан, судалгааг хэлэлцэж, дүгнэлт гаргасан байдал
- Сургалтад оролцогчдоор багшийг үнэлүүлэх
- Багшийн бүхий л үйл ажиллагааны баримт, материал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн ажлын нэгдсэн үнэлгээний (аттестатчиллын) дүрэм журмын хувьд бодлого, концепт сайтайгаар боловсруулан хэрэгжүүлдэг. Бусад их дээд сургуулиудад сайн туршлага нь нөлөөллөө үзүүлж салбартаа үлгэрлэл болдог.
- Сэтгэл ханамжийн судалгааг багш бүрээр сургуулийн SiSi системээр хийдэг бөгөөд сургалтад оролцсон оюутнууд үнэлгээ дүгнэлтээ өгч хэвшсэн. Үүний дагуу багш болон удирдлагууд нь үнэлгээ дүгнэлт өгдөг.
- Багш нар ажлаа өөрийгөө хөгжүүлэх хүрээнд хийсэн ажлууд, эрдэм шинжилгээ, судалгаа, инновац, сургах, суралцах үйл явц, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээ гэсэн 4 бүлэг үзүүлэлтүүдээр нэгдсэн загварын дагуу тайлагнаж, шат шатны

удирдлагууд нь тайланг хэлэлцэж, дүгнэлт өгч ажлын ахиц дэвшилд шаардлагатай зөвлөмжүүдийг өгч ажиллаж хэвшсэн.

- *Багш нарын сургалтад ашиглаж буй аргазүйн хүрээнд судалгаа хийн үнэлэлт дүгнэлт өгч, сайжруулах алхмууд хийдэг.*

Анхаарах асуудал:

- *Сурган, заах арга, эш, мэргэжлийн үйл ажиллагааны хувьд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ жил тутам хийх тухайд материал хэрэгтэй байна.*
- *Сурагчдын сэтгэл ханамжийн судалгаа хийдэг. Харин бүтээлүүд дээр чанарын үнэлгээ хийж байгаа юу? гэдэгт анхаарч ажиллах*
- *Эдгээр үнэлгээ багшийн урамшууллын системтэй хэрхэн уялдаж байгааг тодруулах;*

Зөвлөмж:

- *Мэдээллийн баазтай болох замаар хэр жигд хийж байгаа, ямар ангиллын ажлыг илүү түлхүү хийж байгаа зэргийг үнэлж дүгнэхийг зөвлөж байна. Үүнд: Эрдмийн болон мэргэжлийн үйл ажиллагааг тодорхой ангиллуудаар бүртгэх, эдгээр чиглэлийн үйл ажиллагааны чанарыг үнэлдэг байх;*

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан.

Шалгуур 6. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

6.1. Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Оролцогч болон сонирхогч талуудын эрэлт хэрэгцээ ба агуулгын харьцуулсан шинжилгээ
- Сургалтын агуулга нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцсэн байдал
- Суралцагч хичээл, багшийг сонгон суралцдаг байдал чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.
- Хөтөлбөр дэх хичээлийн хэлбэр, онол, практикийн зохистой харьцааг хангасан байдал
- Үйлдвэрлэл, практик, клиник сургалтын агуулгыг хамтран хэрэгжүүлдэг байдал
- Зайны болон цахим хичээлүүдийг E- контент түвшинд боловсруулан сургалтад ашигласан байдал

- Хичээл хоорондын уялдаа, залгамж холбоог хангасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- *Ажил олгогчдоос Бизнесийн сургуулийн хэмжээнд өргөн хүрээг хамарсан судалгааг сургуулийн санхүүжилтээр 2008, 2012 онд явуулсан байна.*
- *Багилах нөөц бололцоо, хөтөлбөр сонголтын онцлогоос хамааран мэргэжлийн суурь, мэргэшүүлэх багцийн зарим хичээлийг “хамтлаг” – ийн зохион байгуулалтад оруулж, оюутанд багш сонгох бололцоог олгосоноос гадна хичээлийн үр дүнг хамтлагаараа хэлэлцэн дүн шинжилгээ хийж, хичээлийн хөтөлбөрийн агуулгын шинэчлэлийг тасралтгүй хийж байгаа нь давуу талтай байна.*

-

Анхаарах асуудал:

- *Хөтөлбөрийн маппинг хийгдээгүй учир, агуулгын давхардал, хэвтээ болон босоо холбоог харах боломжгүй байна.*
- *Хөтөлбөрийн шинэчлэлтэй холбоотой хичээлийн хөтөлбөрүүдэд шинэчлэлт хийгдсэн боловч, арга зүйн болон үнэлгээний системд цаашид анхаарах.*
- *Зар сурталчилгааны чиглэлээр мэргэших боломжийг хөтөлбөрт суулгасан боловч, хичээлийг заах багшийн хүрэлцээ, нөөц, бэлтгэл хангалтгүй байгаагаас гадна тухайн чиглэлийн багцийг сонгосон оюутанд олгох дипломын загвар, нэршил тодорхой болоогүй байна.*
- *Оюутанд практик дадлага олгох зорилгоор 3 кредитийн үйлдвэрлэлийн дадлага төлөвлөгөөнд туссан боловч, тэнхимийн зүгээс бизнесийн байгууллагуудтай хамтран ажиллах, оюутнаа дадлагад гаргах тал дээр нэгдсэн зохион байгуулалтаар хангахад анхаарах шаардлагатай.*

Зөвлөмж:

- *Маркетингийн менежмент, зар сурталчилгааны менежмент гэсэн 2 чиглэлийн цогц чадамжийг ялгаатай байдлаар нарийвчлан тодорхойлох, хичээлийн уялдаа холбоог энэхүү цогц чадамжид тулгуурлан гаргах;*
- *Хөтөлбөрийн маппинг хийн, босоо болон хэвтээ холбоонд нь хичээлүүдийн уялдаа холбоог хангах;*
- *Чөлөөт сонголтын хичээлүүд тухайн хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүнд хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох;*

6.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг

байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Сургалтын арга зүйг боловсруулсан баримт бичиг, загвар
- Сургалтад ашиглаж буй арга зүй нь мэдлэг бүтээлгэж, хэрэглэж сургахад чиглэсэн байдал
- Сургалтад хэрэглэж буй мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, программ хангамж, техник хэрэгслийн ашиглалтын судалгаа
- Сургалтын арга зүйн судалгаа, дүгнэлт, хөгжүүлдэг байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- *Сургалтад SiSi программыг бүрэн нэвтрүүлж, багш нар энэхүү программыг ашиглан оюутнуудтай идэвхитэй харилцаа үүсгэн, сургалтын материал, даалгавар, бие даалтыг дүгнэхэд ашиглаж хэвшсэн байна. Түүнчлэн цахим бүртгэлийн систем ашигласанаар багш нарын механик ажиллагаа багассан.*

Анхаарах асуудал:

- *Сургалтын арга зүйн хувьд судалгаанд суурилсан их сургуулийн хөгжлийн зорилготой уялдуулан хөтөлбөрийн шинэчлэлд сургалтын арга зүйг хэрхэн өөрчлөгдсөнийг харуулахуйц судалгаа, бодлогын баримт бичиг дутмаг байна.*
- *МУИС – ийн 2015 оны 5 сарын 5 –ны өдөр батлагдсан “Хичээлийн хөтөлбөр боловсруулах заавар” – т сургалтын арга, сургалт явуулах хэлбэрүүд тусгагдаагүй байна.*

Зөвлөмж:

- *Хичээлийн хөтөлбөрүүдийг үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөр, нийлмэл сургалтын хөтөлбөрийн үндсэн зарчмыг баримтлан хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүнтэй уялдуулан шинэчлэх;*

6.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн дүүрэн, үнэлдэг арга зүйтэй, түүнийг байнга сайжруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Мэдлэг, ур чадвар, хандлагын түвшин тогтоох, ахиц дэвшлийг үнэлэх үнэлгээний арга, аргачлал, хэрэглээ
- Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл нэг бүрийн үнэлгээний арга, хэлбэр нь суралцагчдыг тасралтгүй хөгжихөд хөтөлдөг байдал

- Суралцагчийн үнэлгээ нь ил тод, найдвартай, шударга, ижил тэгш зарчмыг хангасан байдал
- Суралцагчийн гаргаж буй амжилтууд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчийг үнэлэх үнэлгээний арга хэрэгслийг хичээл тус бүрийн хувьд тодорхойлж, тестийн сан болон бусад сангуудыг бүрдүүлж, хэрэглээнд оруулсан байна.
- Суралцагч өөрийн үнэлгээг Sisi программ ашиглан харах боломжтой бөгөөд, энэхүү давуу тал дээр тулгуурлан өөрийн менежментийг хийх боломжтой.

Анхаарах асуудал:

- Нийт хичээлийн кейсийн даалгаваруудын 90 орчим хувийг гадаадын бизнесийн байгууллагуудын кейсүүд эзэлж байгаа бөгөөд судалгааны үр дүнг сургалтанд ашиглах, энгийн судалгааны үр дүнгүүдийг сургалтанд ашиглах боломжийг хайх тал дээр анхаарвал, сургуулийн зорилготой нийцнэ хэмээн үзэж байна.
- Семинарын хичээл дээр хийгдэх оюутны бие даалт, төслийн ажил, тайлангийн удирдамж, үнэлгээний рубрикүүдийн боловсруулалт, хэрэглээ харилцан адилгүй байна.

Зөвлөмж:

- Оюутны дүнгийн шинжилгээг хичээл тус бүрээр гарган, улирал бүрийн динамик хандлагыг шинжилж, хөтөлбөрийн агуулгын шинэчлэлд үр дүнг тусган хэрэгжүүлж, хэвиших;
- Оюутны үнэлгээг ил тод, шударга байлгах үүднээс үнэлгээний рубрикүүдийг хэрэглээнд оруулах шаардлагатай;

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө

Хөтөлбөрийн үр дүн нь сургуулийн эрхэм зорилго, зорилтыг хангаж, сонирхогч талуудын эрэлтэд нийцсэн, үнэ цэнэтэй байна.

7.1. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, ажлын байрны нийцлийн судалгааг тогтмол явуулж, хөтөлбөрийн шинэчлэлд тусгаж хэрэгжүүлдэг байдал
- Төгсөгчид, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа
- Төгсөгчид ажлын байраар хангагдах хүртлээ хүлээхэд зарцуулах дундаж хугацаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- *Төгсөгчдийн болон ажил олгогчдын судалгааг хийж, өөрийн төгсөгчдийн мэргэжлээрээ ажиллаж буй эсэхэд үнэлгээ дүгнэлт хийж хэвшсэн байна.*

Анхаарах асуудал:

- *Төгсөгчдийн ажил эрхлэлт, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа, мөшгөх судалгаанууд нэгдсэн байдлаар хийгддэг боловч, судалгааны үр дүнг хэрэглээнд оруулах тал дээр идэвхтэй ажиллах;*

Зөвлөмж:

- *Нэгдсэн байдлаар хийгдэж буй судалгааны үр дүнгүүдийг тэнхим бодлого тодорхойлоход ашиглах, өөрийн дотоодод мэдээллийн сан үүсгэх, судалгааны үр дүнг эргэлтэд оруулахад анхаарах;*

7.2.Хөтөлбөрийн үр нөлөө:

Хөтөлбөр үр дүнгээ үнэлүүлэх, үнэ цэнээ тодорхойлох, ахиц дэвшлээ харуулах нотолгоотой байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрөөр төгсөгчдийн амжилтууд
- Салбар, хөдөлмөрийн зах зээлд эзлэх байр суурь
- Мэргэжлийн салбарын хөгжилд оруулсан хувь нэмэр /Төрийн болон ТББ-ын зүгээс хийсэн үнэлгээ, судалгаа/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- *Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь, ялангуяа мэргэжлээрээ ажиллаж буй хувь өндөр байна.*
- *Маркетинг, худалдааны тэнхим нь Монголын маркетингийн холбоотой нягт хамтран ажиллаж, Монголын маркетингийн салбарт ажил олгогч болон их дээд сургуулийн хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр идэвхитэй ажиллаж байна.*
- *Төгсөгчдийн дунд бизнесийн салбарт мэргэжлээрээ амжилттай ажиллаж яваа удирдах түвшиний хүмүүс цөөнгүй байна.*

Анхаарах асуудал:

- *Хөтөлбөрөөр суралцагсдын шилжих хөдөлгөөн, элсэлт төгсөлтийн динамик мэдээлэлд дүн шинжилгээ дутмаг*

Зөвлөмж:

- *Тухайн хөтөлбөрөөр тасралтгүй суралцсан оюутны эзлэх хувийн жинг (Retention rate) жил бүр тооцон, шилжих хөдөлгөөний мэдээлэлд анализ хийж хэвиших;*
- *Төгсөгчдийн мөшгөх судалгааг тогтмолжуулж, судалгааны санг бүрдүүлэх;*

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Суралцаж буй гадаад оюутны тоо
- Олон улсын хамтарсан хөтөлбөрийн хэрэгжил
- Улсын болон олон улсын чанартай олимпиад, уралдаан тэмцээнд үзүүлсэн амжилт
- Олон улсад магадлан итгэмжлэгдсэн дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- *МУИС – ийн Бизнесийн сургууль нь бизнесийн удирдлагын чиглэлээр Английн NCC хамтарсан хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд, тус тэнхимийн багш нар энэхүү хөтөлбөрийн маркетингийн мэргэжлийн хичээлүүдийг англи хэл дээр зааж байна.*
- *Маркетингийн менежментийн улсын олимпиадад жил бүр 1 – 3 байр эзэлж байсан түүхтэй бөгөөд тус олимпиадад хувийн амжилтаараа тэргүүлж байсан оюутнууд цөөнгүй байна.*
- *ОУ – ын их дээд сургуулиудад дараагийн шатны сургуулиудад суралцах оюутны тоо өсөх хандлагатай байна.*

Анхаарах асуудал:

- *Төгсөгчдийн мөшгөх судалгааг тогтмолжуулж, гадаадад үргэлжлүүлэн суралцаж буй оюутнуудын жил дараалсан мэдээллийн санг бүрдүүлэх;*

- Гадаад оюутны тоо цөөн.

Зөвлөмж:

- Мэргэжлийн экспертүүд, ажил олгогчдын төлөөллөөс хөтөлбөрт үнэлгээ, дүгнэлт хийлгэх;
- Гадаадаас оюутан элсүүлэх, 3+1, 2+2 хөтөлбөрүүдийг өргөжүүлэх тал дээр анхаарах. Ялангуяа бусад салбар сургуулийн хөтөлбөрүүдээс сонгох боломж чөлөөтэй байгаа давуу талыг ашиглах;

7.4. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар олон нийтийг үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллээр тогтмол хангадаг байдал
- Вебсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС – ийн БС – ийн веб хуудас тогтмолжиж, мэдээллийг цаг тухайд нь нийтэлж байна.
- Веб хуудас дахь мэдээлэл иж бүрэн, хөтөлбөрийн талаар болон цаг үеийн үйл ажиллагаа, оюутанд чиглэсэн үйлчилгээний талаар мэдээлэл авах боломжтой.

Анхаарах асуудал:

- Тэнхимийн болон хөтөлбөрийн нарийвчилсан мэдээллийг авах боломж хомс, тэнхимийн веб хуудас байхгүй.

Зөвлөмж:

- Тэнхимийн веб хуудсыг ажиллуулах боломжийг эрэлхийлж, хөтөлбөрийн нарийвчилсан мэдээллийг хүргэх боломжийг оюутнуудад олгох;

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 8. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

8.1.Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээг тогтмол, давтамжтай хийдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуултыг хангах удирдлага, зохион байгуулалтын шийдэл, үр дүн
- Дотоод чанарын баталгаажуулалтын тогтсон бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ
- Дотоод чанарын баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоо
- Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхийг мэдээ баримтад тулгуурлан дүгнэж өөрийн үнэлгээг хийдэг байдал
- Хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах зорилгоор судалгааны үр дүнг хөтөлбөрийн ахиц, дэвшилд системтэйгээр ашигласан байдал
- Хөтөлбөрт орсон өөрчлөлтүүдийн үр нөлөөг хянасан байдал
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд эргэх холбоо үүсгэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- *Чанарын баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангаж ажилладаг. Хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах ажлыг хариуцсан Хөтөлбөрийн Хороо ажиллаж байна. Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааг чиглүүлэх дүрэм журам боловсруулсан, түүний дагуу хөтөлбөрийн сайжруулалт хийгдэж байна. (2016 онд батлагдсан Хөтөлбөрийн хорооны журам: Хөтөлбөрийн Ерөнхий хороо, Ерөнхий суурь хөтөлбөрийн хороо, Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн дэд хороо, Тэнхмийн дэд хороотой байхаар шийдвэрлэн журмыг хэрэгжүүлж байна.)*
- *Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтын нэгжтэй болсон. Чанарын баталгаажуулалт хийх тухайд багш, ажилтнуудаа өндөр хөгжилтэй улс орны сургалтын байгууллагад хандаж сургахаар төлөвлөсөн.*

Анхаарах асуудал:

- *Гарц үр дүнгийн үзүүлэлтүүд тодорхойлогдсон. Гэхдээ гарц үр дүнгийн шинжилгээ хийх ажил багш, хөтөлбөр, сургуулийн түвшинд тогтмол хийгдэхгүй байгаа байдал ажиглагдсан. Хөтөлбөр сургуулийн түвшний үнэлгээ, хяналтыг одоо тодорхой алба хариуцахаар болсон.*
- *Нэгдсэн албан дээр хийгдэж байгаа судалгаа, үнэлгээ хэр ерөнхий эсвэл тухайн хөтөлбөрийн асуудал руу нарийн орж байгааг анхаарах. Чанар хариуцсан нэгж, Хөтөлбөрийн хороо, тэнхмийн чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааг уялдуулах асуудал чухал байна.*

Зөвлөмж

- Чанар хариуцсан нэгж, Хөтөлбөрийн хороо, тэнхмийн үйл ажиллагааг уялдуулах: ажлын зааг, үйл ажиллагаа хэрхэн явах процессоо гаргах нь ажил орхигдох явдлаас сэргийлнэ.
- Ажил олгогчдоос судалгаа авах, түүнийг тогтмолжуулах;

8-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ:

Нэг. Хөтөлбөрийн төлөвлөлт, сургалтын үйл ажиллагаа ба хөтөлбөрийн үр дүнгийн талаар

- Бизнесийн сургуулийн зорилго, хөтөлбөрийн зорилго, зорилт, суралцахуйн зорилтот үр дүн, сургалтын арга хэлбэр, үнэлгээний аргын уялдаа холбоог зураглалаар гаргаж, хөтөлбөрт нарийвчлан тусгах;
- Хичээлийн зорилтот үр дүнгүүд нь хөтөлбөрийн зорилготой хэрхэн уялдаж буйг харуулах хөтөлбөрийн маппинг хийх;
- Хөтөлбөрийн баримт бичигт хичээлүүдийн хоорондын уялдаа холбоо, өмнөх болон давхар холбоог харуулсан схем зураглал хийх;
- Маркетингийн менежмент, зар сурталчилгааны менежмент гэсэн 2 чиглэлээр цогц чадамжийг нарийвчлан тодорхойлж, цогц чадамжид тулгуурлан хичээлийн уялдаа холбоог гаргах;
- Хичээл тус бүрээр улирал тутам гаргасан оюутны сурлагын дүнгийн динамик хандлагыг хөтөлбөрийн агуулгын шинэчлэлд харгалзан үзэхийн зэрэгцээ оюутны үнэлгээг ил тод, шударга байлгах зорилгоор үнэлгээний рубрикүүдийг хэрэглээнд оруулах;

Хоёр.Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл болон хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалтын талаар

- Хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангахуйц идэвхжүүлэлтийн нарийвчилсан хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, сурталчилгаа, идэвхжүүлэлтэнд интернэт, дижитал болон сошиал медиа маркетингийн аргуудыг өргөн ашиглах замаар оролцогч, сонирхогч талуудын анхаарал татахуйц, үр дүнтэй, сонирхолтой шинэ, дэвшилтэт хэлбрүүдийг нэвтрүүлэх;
- Хөтөлбөрийн нэгжээс жил бүр хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөнд зайлиггүй шаардагдах зардлыг тусгайлан төлөвлөж, БС-ийн нэгдсэн төсөвт суулгаж байх;
- Олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоох талаар цаашид идэвхи, санаачилгатай ажиллах;
- Хөтөлбөрийн багш, ажилтнуудын хүний нөөцийн хэрэгцээг урьдчилан тодорхойлж, шалгуур хангасан хүнийг багш, ажилтны нөөцөд бүртгэн тэднийг бодлогоор дэмжих;
- Оюутан солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт оюутан, суралцагчдын хамрагдалтыг нэмэгдүүлэх, гадаад оюутан элсүүлэх, (3+1),(2+2) хөтөлбөрүүдийг өргөжүүлэх чиглэлээр санаачлагатай ажиллах;
- Хөтөлбөрийн хүрээнд төгсөлтийн дараах нэгдсэн бодлогыг тодорхойлох;
- Тайлан, мэдээллийн нэгдсэн “D-Space” системийг бүрдүүлэх;

- Хөтөлбөрийн нэгж болон багш нарын KPI-ийг дүгнэхэд шаардлагатай тайлан мэдээллийн нэгдсэн цахим сантай болох;
- Санал, гомдол хүлээн авах, хариу өгөх системийг бүрдүүлэх;
- Хичээлийн IV байрыг шинээр барьж байгуулах ажлыг эхлүүлэх;
- Маркетингийн мэргэжлийн номын фондыг сүүлийн үеийн шинэ ном, сурах бичгээр баяжуулах, номын санд нэг төрлийн сурах бичгийг худалдан авах тоо хэмжээг нэмэгдүүлэх;
- БС-ийн салбар номын санд маркетингийн мэргэжлийн e - ном, сурах бичгүүдийн цахим сан бий болгох;
- Оюутнуудын ном, сурах бичгийн онлайн эх үүсвэрийн ашиглалтыг сайжруулах;
- Семинар, лабораторийн хичээлийн гарын авлага, хэвлэмэл үзүүлэн, тараах материалыг шинэчлэн боловсруулж, сургалтад өргөн ашиглах;
- Сургалт, судалгаанд албан ёсны лицензтэй программ түлхүү ашиглах;

Гурав. Багш, оюутны үйл ажиллагаа болон чанарын үнэлгээ, баталгаажилтын талаар

- Оюутанд чиглэсэн цогц үйл ажиллагааны зураглал гаргаж оюутан, багшийг мэдээллээр хангах;
- Тэтгэлэгт хамрагдсан болон шилжилт хөдөлгөөн хийсэн оюутны судалгааг тогтмол гаргаж, дүн шинжилгээ хийж хэвиших;
- Үндсэн багш нарын сургалтын ачааллыг батлагдсан нормоос хэтрүүлэхгүй байх, багш нарын захиргааны болон техникийн шинжтэй ажлын оролцоог багасгах замаар тэдний судалгааны ажил гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлэх;
- Багш нарын сургалт, судалгааны үйл ажиллагааны талаархи Boyer-ийн гэх мэт мэдээллийн тусгай санг бий болгож, тэдний эрдэм судлалын болон мэргэжлийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч байх;
- Зөвлөх багшийн ажиллах журам боловсруулах, зөвлөх үйлчилгээний үр дүнг урамшууллын системтэй холбох;
- МУИС -ийн Чанар хариуцсан нэгж, хөтөлбөрийн хороо болон тэнхмээс хариуцан гүйцэтгэх ажлын зааг, ялгааг нарийвчлан тогтоох;
- Хөтөлбөрийн баримт бичигт хөтөлбөрийн өөрчлөлт болон баталгаажуулалт хийх хугацаа, давтамж болон уг ажлыг хариуцан гүйцэтгэх субъектийг тодорхой тусгах;

ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ЭЦСИЙН ДҮГНЭЛТ:

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг МУИС-ийн Бизнесийн сургуулийн “Маркетинг” бакалаврын сургалтын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна. Шинжээчийн багийн дүгнэлтийг Бизнес, удирдлагын хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг/Б.Нарангэрэл/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../С.Эрдэнэтуул/

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2			Нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг мэдэрч, сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрүүдэд шинэчлэлт, сайжруулалт тасралтгүй хийгдэж иржээ.
2	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2			Стандартад нийцсэн сургалт, судалгаа явуулах анги танхим, лабораториудтай. Сургалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийн хангамж сайн. Багшийн ажиллах таатай орчин бүрдсэн байна.
3	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	2			Хөтөлбөрийн удирдлагын зүгээс сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн чанартай сургалт, судалгаа явуулах, нөөцийг оновчтой хуваарлах, багш, оюутны хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэхэд чиглэгдсэн менежментийг амжилттай хэрэгжүүлж байна.
4	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	2			Маркетингийн хөтөлбөрийн оюутнуудад амжилттай суралцах нөхцөл боломжийг бүрдүүлж өгсний зэрэгцээ тэдний суралцах үйл ажиллагааг бүх талаар дэмжин ажиллаж байна.
5	Багшийн үйл ажиллагаа	2			Хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлж чадахуйц онол-практикийн өндөр мэдлэг, дадлага туршлагатай, эрдмийн зэрэг цолтой багшлах бүрэлдэхүүн ажиллаж байна.
6	Сургалтын үйл ажиллагаа	2			Сургалт, судалгааны үйл ажиллагаа нь хөтөлбөрийн зорилгод бүрэн нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээллийн дэвшилтэт технологийг ашиглан явагдаж байна
7	Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө Чанарын үнэлгээ, баталгаажилт	2			Маркетингийн хөтөлбөр нь анх 2009 онд үндэсний хэмжээнд, 2013 онд ОУ – ын ACBSP – ээр магадлан итгэмжлэгдсэнээр суралцагчдын цогц чадамжийг үндэсний болон олон улсын түвшинд хүлээн зөвшөөрүүлсэн байна.

8	Чанарын үнэлгээ, баталгаажилт	2			Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтын нэгжтэй болсон. Чанарын баталгаажуулалт хийх багш, ажилтнуудыг өндөр хөгжилтэй улсад сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.
Дүгнэлт		041401 индекстэй, бакалаврын зэрэг олгох “Маркетинг” хөтөлбөр нь дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагыг бүхэлд нь “ <i>бүрэн хангасан</i> ” гэж үзэж байна.			

V. Оролцогчдын нэрс

I. Ярилцлагад оролцсон багш нарын төлөөлөл

2019.02.27, 15-16 цаг

№	Овог нэрс	Албан тушаал	Заадаг хичээл	Утас	Гарын үсэг
1.	Б.Даваасүрэн	Проф	Хэрэглэгчийн зан төлөв	99096522	
2.	Г.Мөнхбаясгалан	Дэд проф	Маркетингийн үндэс, Шууд маркетинг	99086195	
3.	Г.Урандэлгэр	Ахлах багш	Маркетингийн үндэс, Маркетингийн удирдлага, Үйлчилгээний маркетинг	80002014	
4.	Ч.Батбаатар	Багш	Маркетингийн үндэс, Маркетингийн удирдлага, Маркетингийн судалгаа, Брэндийн удирдлага, Интернэт маркетинг	99054915	
5.	Б.Угтахжаргал	Багш	Маркетингийн үндэс, Нэгдмэл маркетингийн харилцаа, ОУ-ын маркетинг	88118441	
6.	С.Бурмаа	Дэд проф	Маркетингийн үндэс, Маркетингийн судалгаа, ОНХ ба нийгмийн маркетинг	99093569	
7.	Ө.Номинцэцэг	Ахлах багш	Барааны ангилал, гаалийн тариф Гаалийн менежмент: онол ба практик Олон улсын бизнес		
8.	Я.Отгонсүрэн	Зөвлөх проф	Маркетингийн удирдлага, Үйлчилгээний маркетинг	88006085	
9.	Р.Шарбанди	Багш	Маркетингийн үндэс, Шууд маркетинг	99032779	
10.	Н.Батнасан	проф	Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын удирдлага Олон улсын худалдааны бодлого ба практик	99009977	

11.	Ж.Тунгалаг	Дэд проф	Олон улсын бизнес Худалдааны менежмент	88002763	
12.	Ц.Цолмон	Докторант	Гадаад зах зээлийн шинжилгээ Олон улсын бизнес Олон улсын худалдаа Экспорт, импортын удирдлага	99088815	
13.	О.Дашням	Туслах ажилтан	-	88653868	

II. Оюутны төлөөлөл

2019.02.27, 14:00-15:00

№	Оюутны нэрс	Түвшин, голч	Сонгосон байдал	Утас	Гарын үсэг
1.	Д.Батцэцэг	4 түвшин, голч 3+	УБ, оюутны сайн дурын байгууллагын	86669036	
2.	Н.Хүнлэгсайхан	4 түвшин, голч 3+	Оюутны сайн дурын байгууллагын гишүүн	88478008	
3.	Б.Саруул	4 түвшин, голч 2,5-3	УБ, гадуур байрладаг	88553522	
4.	Б.Мөнхсайхан	4 түвшин, голч 2,5-3	УБ, гадуур байрладаг	88988434	
5.	Э.Мөнхдуулга	4 түвшин, голч 2,5-3	Улаанбаатар	88973942	
6.	А.Амаржаргал	4 түвшин, голч 2,5-3	Улаанбаатар	88982108	
7.	Ананд	3 түвшин, голч 3+	Ангийн дарга	88932288	
8.	Liaqi Wu	3 түвшин, голч 2,5-3	Гадаад оюутан	94949888	
9.	Хонгорзул	3 түвшин, голч 2,5-3	Орон нутгийн	88313920 99401665	
10.	Барсболд	3 түвшин, голч 2-2,5	УБ, гэртээ	89008106	
11.	Билгүүн	3 түвшин, голч 2-2,5	УБ, Гадуур амьдардаг	88812363	
12.	Уртнасан	2 түвшин, голч 3+	УБ	88343388	
13.	Нарандулам	2 түвшин, голч 3+	Дотуур байр, клубын гишүүн	91494997	
14.	Номуун	2 түвшин, голч 3+	УБ	91885838	
15.	Энхжаргал	2 түвшин, голч 3+	УБ	99786847	
16.	Саранцогт	2 түвшин, голч 2-2,5	Орон нутгийн	99760917	

III. Ажил олгогчдын төлөөлөл

2019.02.28. 11:30-12:30

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал	Утас	Гарын үсэг
1.	Ариунболд	Монре даатгал	Маркетингийн албаны дарга	80119000	
2.	Батсайхан	UBSTV	Маркетингийн албаны дарга	99067995	
3.	Шинэбаяр	Creative Marketing	Захирал	99083441	
4.	Даваасүрэн	ММCG ХХК	Дэд захирал	99100599	
5.	Мөнхтуяа	Тесо ХХК	Маркетингийн албаны дарга	88109388	

IV. Төгсөгчдийн төлөөлөл

2019.02.28. 10:15-11:15

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага, албан тушаал	Утас	Гарын үсэг
1.	Б.Амгалан	2018	Хувийн компани	86131414	
2.	П. Сувданчимэг	2018	Монре даатгал	90161774	
3.	Түвшинжаргал	2017	Таван богд	99136651	
4.	С. Биндэрьяа	2018	“Эс Ай Си Эй” ХХК	88532188	
5.	Номин-Эрдэнэ	2017	Bloomberg	99997816	
6.	Түвшинжаргал	2016	Төрийн байгууллага	99190162	
7.	Эрдэнэбаяр	2016	REMAX	86098989	
8.	Энхтулга	2015	Петровис	88108802	
9.	М.Цэдэн-Иш	2015	Петровис	99100125	